

Монголын хүн амын нөхөн үржихүй

Ц. Болормаа

Монгол Улсын Их Сургуулийн

Хүн Ам Зүйн Сургалт

Судалгааны Төвийн багш

Оршил

Аливаа улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшинд хүн ам зүйн зохистой бодлого шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг. Ийм ч учраас улс бүр хүн амынхаа тоо хэмжээ, нас хүйсийн бүтэц, хүн амын нөхөн үржихүйн чиг хандлага, хэтийн төлөвийн талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээг хийсний үндсэн дээр хамгийн оновчтой хувилбарыг гарган хэрэгжүүлэх нь улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлоход үндэслэл болох төдийгүй хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах таатай нөхцөл бүрдүүлэх, хөдөлмөрийн нөөцийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох, түүнийг зүй зохистой ашиглах, улс үндэстнийхээ соёл иргэншил, ёс заншлаа хадгалах зэрэг өөр хоорондоо уялдаа холбоо бүхий асуудлуудыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрлэхэд ач холбогдолтой зүйлийн нэг болдог байна.

Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлогын зорилго нь хүн амаа тогтвортой өсгөх, өв тэгш хүмүүжүүлэх, хүний бүх талын хөгжлийн нийгэм, эдийн засаг, орчин ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Иймд энэхүү өгүүллээрээ Монголын хүн амын өсөлт, нөхөн үржихүйн түвшин, чиг хандлага болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн түвшний зарим үзүүлэлтүүдийн талаар бага ч болов үзүүлэхийг оролдсон бөгөөд эцсийн гол зорилго нь нөхөн үржихүйн түвшин, чиг хандлага, ялгавартай байдлыг тодорхойлох явдал юм.

Хүн амын нөхөн үржихүйн түвшин, чиг хандлага

Монгол улс нь цөөн хүн амтай, өргөн уудам нутагтай, хүн амын нягтрал бага, насны бүтэц залуу, нүүдлийн болон суурин соёл иргэншил хосолсон, хөгжиж байгаа орон юм. Хүн амаа тогтвортой өсгөхөд хүн амын бүтэц, байршлын энэхүү онцлог нь чухал үүргийг гүйцэтгэнэ.

Манай улсын хүн ам 1989 оны хүн амын тооллогоор 2044.0 мянгад хүрч 1918 оныхоос 3.2 дахин, 1960 оныхоос 2.2 дахин өсчээ. 1996 оны эхний байдлаар 2313.0 мянган хүн байгаа нь 1918 оныхоос 3.6 дахин, 1960 оныхоос 2.5 дахин өссөн байна. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1950-аад оныг хүртэл 1 хувьд ч хүрэхгүй байсан бөгөөд 1950-аад оноос хойшхи нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин тухайлбал, аж үйлдвэржилт, хотжилт, эрүүлийг хамгаалах системийн хөгжил, мөн тэр үеэс эхлэн хүн амын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хүн амын тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрэлдсэнээр 1950-1960 оны хооронд хүн ам жилд дунджаар 2.34 %-иар, 1970-1980 онуудад 3.32 %-иар өсөн хамгийн оргил үедээ хүрсэн бөгөөд харин 1993-1996 он гэхэд 1.47 % -ийн өсөлтийн хурдтай болон буурчээ. Ер нь ч хүн амын өсөлтийн хурд 1980-аад

оноос буурах хандлага ажиглагдсан байна. Хүснэгт 1-д хүн амын өсөлтийн жилийн дундаж хурдыг 1918–1996 онуудаар, таван жилийн давтамжтайгаар үзүүлээ. Мөн нөхөн үржихүйн зэрэглэлийн түвшинг дээрх үеүүдээр үзүүлэв.

Хүснэгт 1. Хүн амын нөхөн үржихүйн байдал, Монгол, 1918–1996 он		
Хугацааны завсар	Хүн амын өсөлтийн хурд (%)	Хүн амын нөхөн үржихүйн байдал
1918–1935	0,82	Удааширсан үе
1935–1940	0,01	
1940–1945	0,55	
1950–1955	1,80	Нэн хурдан үе
1955–1960	2,65	Хэт хурдан үе
1960–1965	2,97	
1965–1970	2,87	
1970–1975	3,15	
1975–1980	3,02	
1980–1985	2,62	
1985–1990	2,60	
1990–1993	1,90	Нэн хурдан үе
1993–1996	1,47	Хурдан үе


Мэдээллийн эх үүсвэр: "Монгол Улсын хүн ам", УСГ, 1994

Аливаа улс орны хүн амын тооны жилийн дундаж өсөлтийн хувиас нь хамааруулан хүн амын нөхөн үйлдвэрлэлийг: буурч буй, зогсонги болсон, удааширсан, дунд зэргийн хурдацтай, хурдан, нэн хурдан, хэт хурдан гэсэн 7 зэрэглэлд хуваадаг. Манай улсын хүн амын нөхөн үйлдвэрлэлийн байдал 1950–аад оноос өмнө "удааширсан" байсан нь тэр үеийн улс төрийн байдалд гарсан зохисгүй хандлага, 1939 оны Халхголын, 1945 оны чөлөөлөх дайн, эмэгтэйчүүдийн дунд бэлгийн замын халдварт өвчин их, эрэгтэйчүүдийн ихэнх хувь нь сүм хийдэд шавилан сууснаар төрөлтийн түвшинд сөргөөр нөлөөлсөн, хүн амын дунд халдварт өвчин маш их, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй, амьжиргааны түвшин доогуур, хүн амын аж амьдрал туйлын дорой байсны үр дүн юм. Ийнхүү хүн амын нөхөн үржихүйн зүй тогтол ноцтой алдагдсан оронд тооцогддог байсан бол сүүлийн 40–өөд жилийн хугацаанд хүн амын нөхөн үйлдвэрлэлээрээ "хэт хурдан" бүлэгт багтдаг болсон ба 1990–ээд оноос хойшхи хүн амын өсөлтийн хурдны аажим бууралтын үр дүнд нөхөн үйлдвэрлэл "хурдан" бүлэгт багтах болж ирээдүйн чиг хандлагаараа хүн амын нөхөн үржихүйн энгийн байдалд хүрэхэд нэг их холгүй байгаа нь харагдаж байна.


Хүн амын нөхөн үржихүйн дээрх хандлагыг тодруулан үзэх үүднээс хүн амын ердийн өсөлтийн коэффициентийг тооцож үзлээ. Ердийн

өсөлтийн коэффициент нь нөхөн үржихүйн түвшинг тодорхойлогч үзүүлэлтүүдийн нэг бөгөөд 1000 хүн ам тутамд ногдож буй ердийн өсөлтийн хэмжээг илэрхийлдэг.

Монголын хүн амын ердийн өсөлтийн үзүүлэлт (Зураг 1-ийг үз.) 1930-аад оны эхэн үед 1000 хүн ам тутамд +2.2 буюу жилд 2 хүнээр нэмэгддэг байсан бол 1936-1939 онуудад 1000 хүн тутмаас жилд 4 хүнээр хорогддог болжээ.




Харин 1975 онд энэ үзүүлэлт 13.5 дахин нэмэгдэж +29.8 буюу жилд 30 хүнээр нэмэгддэг болсон ба 1980-аад оны эхнээс аажмаар бууран 1993 он гэхэд 1000 хүн тутамд жилд 14 хүн нэмэгддэг болжээ. Сүүлийн 3 жилийн хугацаанд ялимгүй өсөлт ажиглагдсан бөгөөд ердийн өсөлтийн түвшин тогтворжих хандлагатай байна. Магадгүй энэ нь нийгэм эдийн засгийн үйл явц сүүлийн 2-3 жилийн хугацаанд харьцангуй тогтворжиж байгаатай холбоотой төдийгүй хүн амын шилжилтийн тогтвортой үедээ Монгол хүрч ирж байгаагийн дохиолол байж ч болох юм.




Хүн амын нөхөн үржихүйн түвшинг илэрхийлэгч үзүүлэлтийн нэг нь төрөлт/нас баралтын харьцаа юм. Энэ нь 100 нас баралтад ногдож буй төрөлтийн хэмжээг илэрхийлнэ. Зураг 2-оор хүн амын төрөлт/нас баралтын харьцааг үзүүлэв. Төрөлт/нас баралтын харьцаа 1935 онд 113:100 байсан бол 1940-өөд оноос өсөн улмаар 1990 он гэхэд 417:100 болж, 1991 оноос бууран 1996 онд 336:100 болжээ. Энэ харьцааны зүй тогтол нь нөхөн үржихүйн бусад үзүүлэлтүүдийн чиг хандлагатай ижилхэн байгаа бөгөөд хэрвээ энэхүү хандлага цаашид хадгалагдвал Монголын хүн амын нөхөн үржихүйн түвшин тогтворжих шатандаа орох ба хүн амын тогтвортой өсөлтийг хангах нөхцөлийг бүрэлдүүлэх боломжийг бий болгох болов уу гэж санаж байна.

Төрөлтийн нийлбэр коэффициент нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тухайн үеийн төрөлтийн түвшин хэвээр хадгалагдах нөхцөлд нэг эмэгтэйн юмуу 1000 эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлэх дундаж хүүхдийн тоог илэрхийлдэг. Манай улсын нөхөн үржихүйн насны нэг эмэгтэй 1970-аад оны үед амьдралынхаа туршид 7.5 хүүхэд төрүүлдэг байсан бол 1970-аад оны дунд үе, 1980-аад оноос эхээс эхлэн аажмаар буурсаар 1993 онд 2.5 болсон бөгөөд харин сүүлийн 3 жилийн хугацаанд бага зэргийн өсөлт ажиглагдан 1995 онд 2.9, 1996 он гэхэд 2.5 болсон байна. Хэдийгээр нэг эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин сүүлийн 20-иод жилийн хугацаанд буурсан ч гэсэн төрөлт өндөр байсан 1970-аад оны үед төрсөн олон тооны охид нөхөн үржихүйн насандаа буюу хүүхэд төрүүлэх насандаа аль хэдийн хүрч жилд шинээр төрөх хүүхдийн тоо олон байх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.



Иймд нэг эмэгтэйд ногдох төрөлтийн тоо буурсан ч, бүр тодруулбал нэг эмэгтэй бүхий л амьдралынхаа турш нэгхэн хүүхэд төрүүлсэн ч дараа дараагийн жилүүдэд хүн ам өссөөр байх болно. Зураг 3-д төрөлтийн нийлбэр коэффициент болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн өсөлтийн түвшинг үзүүллээ. Эндээс төрөлтийн түвшин буурсан хэдий ч

нийт хүн амд эзлэх нөхөн үржихүйн насны буюу төрөх насны эмэгтэйчүүдийн хувь өсөж байгааг харж болно. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн нийт хүн амд эзлэх хувийн жин 1994 оныг хүртэл байнга өсөж байсан бөгөөд сүүлийн 3 жилийн хугацаанд тогтвортой өсөлтийн үе дээ оржээ гэж хэлж болохоор байна. Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо өсөхийн хамт түүний дотор төрөлтөд гол үүрэг гүйцэтгэдэг буюу хамгийн өндөр төрөлтийн түвшинтэй байдаг 20–29 насны залуу эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 1956 онд 31.3% байсан бол 1993 онд 39.4% болсон бөгөөд сүүлийн жилүүдэд 37.7% болсон нь өсөлтийн тогтвортой байдал ажиглагдаж байгаа юм.



Ингэж 15–49 насны эмэгтэйчүүдийн тоо өссөнөөр жилд төрөх хүүхдийн тоо нэмэгдэх тааламжтай боломжийг бүрэлдүүлж байгаа бөгөөд эцэст нь хэлэхэд манай улсын нийгэм эдийн засгийн өөрчлөлт тогтворжих тийшээ хандвал төрөлтийн түвшин хадгалагдах, хүн амын өсөлтийн тогтвортой хандлага бий болох боломж бүрэлдэж магадгүй байна.

Хүснэгт 3–д хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувийн жинг сонгосон зарим үзүүлэлтүүдээр үзүүлэв. Насны ялгавартай байдлаар харахад 35–аас дээш насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин тууштай буурсан байхад бусад насны бүлгийнхний хувьд бууралт төдийлэн ажиглагдахгүй байна. Харин 20–24 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн түвшин эрчимтэй нэмэгдсэн байна. Ер нь ч 20–29 насны эмэгтэйчүүдийн төрөлт хамгийн өндөр буюу энэ насны бүлэгт төрөлтийн ихэнх хувь нь төвлөрч байна. Хамгийн сүүлийн он буюу 1996 онд төрөлтийн түвшин бага зэрэг буурсан бөгөөд үүний хамгийн гол шалтгаан нь 20–24 насны эмэгтэйчүүдийн төрөлтийн бууралт бусад насны бүлгээс хамгийн ихээр буурсантай холбоотой болов уу.

Хүүхэд төрүүлсэн эхчүүдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл боловсролын түвшин буурах тусмаа төрөлтийн түвшин өндөр байгаа нь харагдаж байна.

Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн 86 орчим хувь нь гэр бүлтэй эмэгтэйчүүд байна. Харин хүүхэд төрүүлсэн гэр бүлгүй эмэгтэйчүүдийн хувийн жин олон жилийн үзүүлэлтээр буурч байгаа хандлагатай хэдий ч сүүлийн жилийн байдлаар гэр бүлгүй хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн хувийн жин ялимгүй нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүд, сонгосон үзүүлэлтээр, Монгол, 1980-1994

Сонгосон үзүүлэлт	1980	1985	1990	1994	1996
Насны бүлэг					
15-19	6,6	5,2	5,9	8,5	7,2
20-24	30,7	32,4	33,9	38,8	37,7
25-29	26,7	33,7	33,0	28,9	30,7
30-34	16,3	15,9	17,7	15,4	15,8
35-39	11,6	7,9	6,9	6,2	6,8
40-44	6,3	3,6	2,0	1,8	1,7
45-49	1,8	1,2	0,5	0,4	0,4
Боловсролын түвшин					
Боловсролгүй	1,9	0,7	0,5	0,9	0,7
Анхан шатны	31,5	18,6	8,7	7,7	6,2
4-8-р анги	35,7	40,3	38,7	40,0	42,0
9-10-р анги	16,5	22,4	32,8	35,1	35,2
Мэргэжлийн	10,2	12,5	13,5	11,5	10,4
Дээд	4,2	5,7	5,9	4,8	5,5
Гэрлэлтийн байдал					
Гэрлээгүй	14,6	13,9	13,5	13,5	14,1
Гэрлэсэн	85,4	86,1	86,5	86,5	85,9
Бүгд	100,0	100,0	100,0	100,0	100,0

Мэдээллийн эх үүсвэр: "Монгол улсын эмэгтэйчүүд, хүүхэд", УСГ, 1995

Энэ нь магадгүй эмэгтэйчүүд маань гэр бүлээ батлуулахаасаа өмнө хүүхдээ төрүүлэх хандлага ихэссэнтэй холбоотой бөгөөд нөгөө талаар гэрлэлтээс гадуурхи бэлгийн амьдрал нэмэгдэж байгааг харуулж байж ч болох юм.


Нөхөн үржихүйн эрүүл мэнд

Сүүлийн үед дэлхийн нийтийн судлаачдын нэлээд анхаарлаа хандуулж байгаа асуудлын нэг нь нөхөн үржихүйн эрх ба эрүүл мэндийн тухай асуудал юм. Нөхөн үржихүйн эрх нь олон улсын хүний эрхийн түгээмэл тунхаглал, улс үндэстнүүдийн үндсэн хууль дээр үндэслэгддэг. Энэ нь хосууд болон хувь хүмүүс хэдэн хүүхэдтэй болох, төрөлтөө хэдэн сар жилийн зайтайгаар зохицуулахаа өөрсдөө шийдвэрлэх эрхтэй гэсэн үг юм. 1994 онд Кайр хотноо хуралдсан "Хүн ам ба Хөгжил" сэдэвт олон улсын

бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөрт "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал дэлхийн олон мянган хүний дургүйцлийг хүргэж байгаагийн гол учир нь хүн төрөлхтний бэлгийн харьцааны талаарх ойлголт шинжлэх ухааны үндэслэл муутай, бэлгийн халдварт өвчний тархалт их, нийгмийн гажуу дадал зуршил, эмэгтэйчүүд, охидын эрх хягаарлагдмал зэрэгт оршино. Ийс учраас бид үүнийг өөрчлөх ёстой бөгөөд өөрчлөх ч болно" гэж цохон тэмдэглэжээ. Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийн түвшинг илэрхийлдэг хэд хэдэн гол үзүүлэлтүүд байдаг. Үүнд:

1. 15–19 насны өсвөр үеийнхний төрөлт
2. Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгслийн (ЖУСХ) хэрэглээний түвшин
3. Нөхөн үржихүйн рисковийн индекс
4. Нэг эмэгтэйн амьдралынхаа туршид төрүүлж буй хүүхдийн дундаж тоо
5. Тухайн улс орны үр хөндөлтийн талаарх бодлого
6. Үр зулбалтад өртөгдсөн эмэгтэйчүүдийн хувийн жин
7. Цус багадалттай жирэмсэн эмэгтэйчүүдийн хувийн жин
8. Эмэгтэйчүүдийн үргүйдэлт
9. Эмэгтэйчүүдийн доторх бэлгийн замын халдварт өвчин болон ДОХ-ын түвшин
10. Эмнэлэгт төрсөн эхчүүдийн хувийн жин
11. Эхийн эндэгдэл г. м.

Эхчүүдийн хүүхэд төрүүлэх үеийн дундаж нас нь нөхөн үржихүйн эрүүл мэндэд онцгой үүргийг гүйцэтгэдэг. Ялангуяа эмэгтэйчүүд нас бие гүйцээгүй байхдаа буюу хэт ахимаг насандаа төрөх нь хүүхэд эндэх, өөрөө ч эндэгдэлд орох магадлал их байдаг билээ. Иймд эх нялхсын эндэгдлийг тууштай бууруулахын тулд хүн амд нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар мэдлэг олгох, эмэгтэйчүүдийн хэт залуу буюу хөгшин насандаа, хэт ойрхон төрөхөөс сэргийлэх үйл ажиллагааг өөрийн улсын онцлогт тохируулан хэрэгжүүлэх хэрэгтэй.



Дэлхийн нийтийн хэмжээнд 15–19 насны охид 255 сая гаруй байдаг бөгөөд тэдгээрийн 11 орчим хувь нь хүүхэд төрүүлжээ. Хөгжингүй орнуудад 1000 амьд төрөлтөд 19–өөс доош насны охидын төрөлт 32, хөгжиж буй орнуудад 65, харин буурай хөгжилтэй орнуудад 140 гаруй

ногддог байна. Манай орны хувьд 1000 амьд төрөлтөд 15-19 насны охидын төрөлт 1985 онд 53 байсан бол 1990 онд 61, 1993 онд 96 болон өссөн бөгөөд харин сүүлийн 3 жилийн хугацаанд эрчимтэй бууран 1996 он гэхэд 72 болсон байна. Ер нь ч өсвөр насны охидын төрөлтийн түвшин дэлхийн ихэнх орнуудад буурч байгаа хандлага ажиглагдаж байна.

Өсвөр насны охидын төрөлт нь тэдний боловсролын түвшинд нэлээд сөргөөр нөлөөлдөг. Ихэнх 17-оос доош насны охид төрснийхээ дараагаар сургуулиа орхиход хүрдэг байна. Тухайлбал, 13-15 насны хүүхэд төрүүлсэн охидын 26% нь сургуульдаа буцаж орсон байхад 15-17 насны охидын дөнгөж 17-хон хувь нь сургуульдаа буцаж оржээ. Үлдсэн 80 орчим хувь нь сургуулиас завсардаж байгаа бөгөөд тэдний энэ байдал нь хүүхэд болон эхийнх нь эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй юм. 19-өөс доош насны өсвөр охидын төрөлтийн нийт төрөлтөд эзлэх хувийн жинг авч үзэхэд манай улсын хувьд бусад орнуудтай харьцуулахад нэлээд доогуур байна. (Зураг 5-ийг үз).

Ашигласан материал

1. Улсын Статистикийн Газар (1994), "Монгол улсын хүн ам", Улаанбаатар
2. УСГ (1995), "Монгол улсын эмэгтэйчүүд, хүүхэд", Улаанбаатар
3. УСГ (1997), "Монгол улсын хүн ам 1996 онд", Улаанбаатар
4. Эрүүл Мэндийн Яам (1992), "Гэр бүл төлөвлөлтийн анхдугаар хуралдаан", Улаанбаатар
5. Henry S. Shryock, Jacob S. Siegel & Associates, "The Methods and Materials of Demography"
6. Pollard A.H., Farhat Yusuf, Pollard G.N., "Demographic techniques"
7. Zahidul Huque, "Maternal Mortality and Fertility: Implications for Mongolia"
8. Neupert F. (1991), "Mongolia: Recent Demographic Trends and Implications"